

# Манмин Мэдээ

Номер 27 2012 оны Аравдугаар сарын 7

## Манмин төв сүм байгуулагдсаны 30 жил

Итгэлээрээ давшиж ирсэн энэ хугацаанд 10,000 гаруй салбар сүм болон хамтарсан сүмүүдтэйгээ хамт дэлхий даяар ариун сайн мэдээг тунхаглаж буй Манмин төв сүм



### Хоньчны Сэтгэл

Зөвхөн дуулгавартай байдлаар Бурхан Аавын  
Тэр хүслийг биелүүлэх хүртэл  
Нулимс бас нулимсын гүн залбирал  
Юугаар ч хэмжээлшгүй ээ  
Аавын сэтгэлд орших Тэр угийн хайр  
Олон хүмүүсийг амилуулах хүртэл  
Энэрэл болон гашуудлын хайрын  
залбиралд Юу ч саад болохгүй ээ

Хэцүү зүйл тохиолдсон ч үргэлж  
итгэлийн үйлсээр  
Аавын хүслийг биелүүлэх хүртэл  
Аавдаа алдар ба хайрын үр жимсээр  
Аавын баяр хөөр болно.  
Угийн гэрлээр Ариун Сүнсний гал  
мэт хүч чадлаар  
Харанхуйг хөөн зайлуулж шударга  
байдлыг гэрэлтүүлнэ  
Хязгааргүй Бурхан Аавын минь  
хайрын орон зай  
Олон хүмүүст илчлэгдэж байна.

2012 оны Долдугаар сарын 25-ны өдөр манай төв сүм байгуулагдсаны 30 жилийн ой болж өнгөрлөө. Анх 7-хон мянган вон 33 квадрат метр талбай бүхий давчуухан өрөөнд 13 гишүүнтэйгээр байгуулагдаж байсан манай төв сүм одоогийн байдлаар дэлхий даяар нийт 10,000 орчим салбар сүмүүд болон хамтарсан сүмүүдтэй болсон билээ. Мөн "GCN" ТВ болон олон орны хэлээр орчуулагдан гарсан христэч ном сонин, сэтгүүлүүдээр дамжуулан дэлхий дахинд ариун сайн мэдээ ба эрх мэдэлт хүчийг тунхаглан Бурханы хайрыг дамжуулахдаа үй олон хүмүүсийг авралын зам руу удирдаж байгаа билээ. Манмины 30 жилийн түүх нь зөвхөн Ариун Сүнсний удирдамжаар бий болсон зүйл юм.

1974 онд Бурхантай уулзаж

бүхий л өвчнөөсөө нэг дор эдгэрсэний дараа Эзэний боолоор дуудагдсан (тухайн үеийн) И Жей руг номлогчид сүм байгуулах тухай залбирал хийж байх зуур "нар ид халуунаар төөнөх үед сүм байгуул" гэсэн үгийг Бурханаас хүлээн аваад тэр үгийн дагуу 1982 оны Долдугаар сарын 25-нд, сүмээ байгуулж "Эрдэнийн дээд эрдэнэ Итгэл" хэмээх сэдвээр анх сургаал айлдсан юм.

Үйлс номон дээр гардаг шиг анхны цуглааны итгэгч нар сүмдээ өдөр бүр цуглацгааж Бурханы хаанчлал ба зөвт байдлыг төлөө гал мэт халуунаар залбирахад дэлхий даяар сайн мэдээ тараах Их өргөө сүмийг барьж байгуулах талаар алсын харааг өгсөн билээ. Мөн Эзэний дагалдагч нарын үгийг дагалдах тэмдэг гайхамшгаар баталж байсаний адил И Жей руг пастораар

дамжуулан Бурханы эрх мэдэлт хүчит үйлсүүд бий болон сүм сэргэлтээс сэргэлт рүү дэвжсээр байгаа билээ.

1990 онд энэ мэт эрч хүчтэй сэргэсээр Америкид хэвлэгдэн гардаг "Христийн Ертөнц" хэмээх сэтгүүлд "Дэлхийн 50 том сүмүүдийн" тоонд орж 2000 оноос хойш АНУ, Пакистан, Энэтхэг, Орос болон Герман зэрэг гадаадын олон газруудад олон зуун мянга, олон сая хүмүүсийг цугларсан нэгдсэн их цуглааныг удирдан явуулсан юм. Ялангуяа 2009 онд хийгдсэн Израйль Иерусалим хотод болсон Израйлийн нэгдсэн их цуглааны үйл ажиллагаанд зөвхөн Есүс л хүн төрөлхтөний цорын ганц Аврагч хэмээн тунхаглаж сайн мэдээний шинэ эргэлтийг бий болгосон юм.

Зөвхөн дуулгавартай байдал болон хайраар бий болсон

Манминий 30 жилийн түүхэнд талархалын үр жимс арвин их билээ. Эзэний зүрх сэтгэлийг дуурайх гэж хичээж итгэгч нар асар хурдацтай сүнсэлэг урсгалд итгэлийн хадан суурин дээр зогссон тул сүнс сэтгэл сайжирч төгс сүнсний зүрх сэтгэлтэй үр жимс болсноор хамгийн үзэсгэлэнтэй тэнгэрийн орон болох Шинэ Иерусалимд итгэлээр эзлэн орж байгаа билээ.

Мөн одоогийн байдлаар 176 оронд GCN ТВ-н(www.gcntv.org) нэвтрүүлгээр дэлхий дахинаа манай төв сүмийн сургаалиуд цацдаг бөгөөд өдрөөс өдөрт үзэгчдийн тоо нэмэгдсээр байгаа билээ. Түүнчлэн И Жей руг пасторын итгэлийн амьдралын тухай христэч номуудыг орчуулан хэвлэдэг "Урим ном" хэвлэлийн газар,(www.urimbooks.com) Манмин ОУ-н библийн сургууль

MIS (Manmin International Seminary) болон Дэлхий христэд итгэгч эмч нарын холбоо WCDN (World Christian Doctors Network) зэрэг олон төрлийн байгуулагыг бий болгон дэлхий даяарх бүх үндэстэнд Ариун сайн мэдээг тарааж байгаа билээ.

Манай Манмин сүм нь гэм нүглээр дүүрсэн хүн төрөлхтөний эцсийн энэ цаг үед хүний зүрх сэтгэлийг ч өөрчлөх Бурханы гайхамшигт хүч чадлаар үй олон хүмүүсийг аварч Бурханы хаанчлалыг өргөжүүлэх болно. Мөн түүнчлэн Бурханы ерөөлөөр дамжуулан Их өргөө сүмийг барьж байгуулах эхлэл болох Канаан сүмийг байгуулан Эзэн дахин үе хүртэл эцсийн үеийн төлөвлөгөөг биелүүлэх болно. Арвин их үр жимс болон үргэлж хамтдаа байсан Бурхандаа бүхий л талрахал ба алдрыг өргөө!



# Мөнхийн Амьдрал (2)

## Хүний Хүүгийн мах ба цусыг идэж ууснаар мөнх амьдрал (2)

“Есүс тэдэнд-Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Хүний Хүүгийн махыг идэхгүй, цусыг нь уухгүй л бол та нарын дотор амь байхгүй. Миний махыг идэж, цусыг уусан хүн мөнх амьтай бөгөөд Би түүнийг эцсийн өдөрт амилуулна. Учир нь Миний мах бол жинхэнэ хоол, Миний цус бол жинхэнэ ундаа мөн.” (Иохан 6:53-55)



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Есүс Христ бол хүн төрөлхтөний Аврагч Эзэн болохыг мэдээд, тэнгэрийн орон ба там байдаг гэдгийг зөвхөн мэдлэг төдий мэддэг бол аврал хүртэх боломжгүй бөгөөд үүнд заавал Хүний Хүүгийн мах ба цусыг идэж ууснаар л мөнх амьдрах боломжтой билээ.

Тиймээс Иохан 6:53-д, “Хэрэв та нар Хүний Хүүгийн махыг идэхгүй, цусыг нь уухгүй л бол та нарын дотор амь байхгүй,” хэмээн айлдсан байдаг ба мөнхийн амьдрал нь Хүний Хүүгийн мах ба цусыг идэж ууж байж л мөнх амийг хүртдэг болохыг зааж өгч байна.

Хүний Хүүгийн мах ба цусыг хэрхэн идэж ууснаар мөнх амьтай болох вэ?

### 1. Хүний Хүүгийн мах буюу Бурханы Үгийг өөрийн шим тэжээл болгож, зүрх сэтгэлээ үнэнээр дүүргэх

Бид бүхэн амьдрахын тулд олон шим тэжээлийг авч, идэж уух ёстойн адил Хүний Хүүгийн махыг идэж өөрийн төгс шим тэжээл болгохын тулд заавал Хүний Хүүгийн цусыг мөн уух хэрэгтэй байдаг билээ. Өөрөөр хэлбэл, библид бичигдсэн Бурханы сургаалиудыг хичээнгүйлэн уншиж сонсон мэдлэг болгон хураах бус тэр үг сургаалиудыг өөрийн амьдралдаа биелүүлэн хэрэгжүүлэх гэсэн үг юм.

Тэгвэл “Бурханы Үгийг зүрх сэтгэлдээ хэрэгжүүлэх” ба “мэдлэгээр хураах” гэдэг нь ямар ялгаатай вэ? Хүн тархиндаа оруулсан зүйлсээ мартахаар амархан тул үнэнийг мэдлэг болгон хураасан болгоноо түүний дагуу үйлдэж чаддаггүй юм.

Библи ишлэл цээжлэхэд гэсэн амаараа

л цээжлэх бус түүний сүнслэг утга учрыг санаж, зүрх сэтгэлдээ оруулах ёстой билээ. Жишээлбэл, Матай 5:44-д, “Дайснуудаа хайрла, та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир” хэмээн айлдсан ишлэлийг та зүрх сэтгэлдээ оруулсан бол та амьдралдаа ингэж хэрэгжүүлсэн үйлдэл гарах ёстой билээ.

Дайсагнан, атгаг байдлыг үйлдэж, таныг хавчих үед Бурханы сургаалийн дагуу тэр хүнийг хайрлан харин ч түүний төлөө залбирал үйлдэх хэрэгтэй байдаг. Хэрэв зөвхөн толгойдоо мэдлэгээр хураасан бол сэтгэл тавгүйтэж, үзэн ядан, тэр ч байтугай атгаг байдлыг нь мөн буцаан атгагаар хариулдаг бол энэ үгийг өөрийн болгосон хүн нь ийм үед аяндаа хайр, ба энэрэх сэтгэл үйлддээр гардаг.

Ингэж Хүний Хүүгийн махыг өөрийн шим тэжээл болговол хуал хуурмагаар дүүрсэн хар сэтгэл нь бага багаар цагаан болж өөрчлөгдөхийг хэлж байгаа билээ. Тэгээд хайр, дөлгөөн байдлыг өөртөө хэрэгжүүлэх тусам үзэн ядалт, уур бухимдлаас ангижирч, даруу байдлыг өөртөө авах тусам эцэстээ бардам занг орхин хаядаг болохыг харж болно.

### 2. Хүний Хүүгийн махыг идэж хэмжээгээр Хүний Хүүгийн цусыг уух ёстой

Бурханы Үгийг өөртөө сайн шингээхийн тулд Ариун Сүнсний бялхал дотор ухаарч ойлгох төдийгүй гал мэт халуун залбирлаар дамжуулан Бурханы ивээл ба хүчийг авах ёстой билээ. Тэгэхэд зайлшгүй хэрэгтэй зүйл нь тэр сургаальд итгэн түүнчлэн сахин биелүүлэх өөрийн хичээл зүтгэл заавал хэрэгтэй юм. Энэ сахин биелүүлэх хичээл зүтгэлийг Хүний Хүүгийн цусыг ууж байна гэж тайлбарлаж байгаа юм.

Тиймээс, “Хүний Хүүгийн цусыг уух” гэдэг нь Бурханы Үгийг итгэлээрээ үйлдэж хэвшинэ гэсэн утгатай. Хичнээн их Бурханы сургаалиудыг сонсож мэдэн, тунгаан бясалгаж, биелүүлэх гэж залбирал хийсэн ч гэсэн үйлдсэн үйлдэл байхгүй бол ямар ч үр дүнгүй хий хоосон зүйл болох билээ.

Бурханы сургаалийг дараах байдлаар дөрөв хувааж болно. Юу юуг “Сахь,” “Хая,” “Хий” ба “Бүү хий” хэмээн айлдсан түүнчлэн сахин үйлдэх ёстой

билээ. Ийм үйлс байхгүй бол Бурханы хүч чадлыг мэдрэх боломжгүй бөгөөд ингэж мэдрэх боломжгүй бол сонсож сурсан мэдлэг төдий итгэл нь цаашид өсөх боломжгүй болох билээ.

Иаков 2:22-нд, “Итгэл нь түүний үйлстэй хамт ажиллаж байсныг, итгэл нь үйлсээр гүйцэд болсныг ч харж байна.” хэмээн айлдсанчлан итгэлээр үйлдэж байж л мэдлэг төдий итгэл нь сүнслэг итгэлээр төгс болох юм. Анхандаа гичийн үр шиг маш жижиг итгэлтэй байсан ч гэсэн үйлсээр гарч ирэхэд Бурхан ивээл ба хүчийг мэдрүүлэн өгч, өдөр өдрөөр итгэлийг нь өсгөн, агуу итгэлтэй болохыг тулд удирдан хөгжүүлдэг билээ.

Бурханы үг сургаалд итгэн үйлдэх үед “Христийн төлөвшсөн итгэл” (Ефес 4:13) хүртэл өсөн, Бурханы сургаалийг төгс өөрийн шим тэжээл болгон хэрэгжүүлэх болдог.

Харин үүний эсрэг Ариун Сүнсний хүлээн авч дараах гичийн үр мэт итгэлтэй байсан ч үйлс байхгүй бол хичнээн удаан хугацаанд итгэлийн амьдралаар амьдарсан ч сүнс зүгийн зүйлсийг мэдрэх боломжгүй бөгөөд зүрх сэтгэл ч өөрчлөгдөхөд хэцүү юм. Тэгж байгаад тэр өчүүхэн итгэлээ ч гэсэн алдан авралаас ч холдож болзошгүй гэдгийг санан Хүний Хүүгийн цусыг уух үйлдлээр итгэлээ төгс болгохыг хүсэж байна.

### 3. Үйлсгүй итгэл бол үхмэл итгэл

Бурхан биднийг сургаалийн дагуу амьдарвал энэ газар дээр төдийгүй тэнгэрийн оронд орсон ч ерөөх болно хэмээн амласан байдаг. Мөн түүнчлэн бүх зүйлд итгэлээрээ Бурхандаа л найдан түшиглэх аваас ямар ч хүнд хэцүү асуудлыг ч шийдэж өгнө хэмээн амласан билээ.

Ингэж Бурханы үгэнд үнэхээр итгэдэг бол заавал үйлс дагалдах ёстой билээ. Нэгэн хүн танд Вашингтон хотоос алхаад Нью Йорк хүртэл (331 километр) алхвал хэдэн арван саяын үнэтэй эрдэнэс өгье гэж амласан гэж бодъё. Тэгвэл та тэр эрдэнэсийг авахыг хүсч байгаа, мөн энэ хэмжээний зүйлийг өгч чадах хүн ингэж амлавал та тийшээ явахгүй байсан гэж үү!

Тиймээс Иаков 2:26-д “үйлсгүй итгэл нь үхмэл юм” хэмээн айлдсан байдаг. Олон хүмүүс зөвхөн амаараа “Би бүхнийг чадагч Бурханд итгэдэг” гэж хэлдэг ч зүрх сэтгэлдээ төгс итгэдэггүй

учраас итгэлийн үйлс дагадаггүй билээ. Бурханы сургаалийн дагуу үйлддэг сүнслэг итгэлийг олж байж л аврал авах боломжтой төдийгүй Бурханаас хариулт ба ерөөлийг авах боломжтой юм.

Ром 10:13-д “Эзэний нэрээр дуудах хэн ч аврагдах болно” гэсэн тул амаараа Эзэний нэрийг дуудвал хичнээн гэм нүгэлтэй хүн ч гэсэн аврал хүртэх боломжтой гээд өөрийн гэмээ цайруулах гэдэг. Гэвч, энэ ишлэл нь үхэхээс өөр аргагүй гэмтнүүдийг Есүс Христийн нэрээр аварсан Бурханы хязгааргүй хайрыг илэрхийлсэн болохоос биш хууль бус зүйлсийг үйлддэг хүмүүсийн хорон мууг далдлах гэсэн ишлэл огтхон ч биш юм.

Бурханы үг нь хос хосоороо ижил тул урд хойд залгаа ишлэлүүдийг ажиглан, Ариун Сүнсний тусламжтайгаар тайлж байж л ойлгох боломжтой. Ром 10:9-10-д “Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ.” хэмээн айлдсан байдаг тул зүрх сэтгэлдээ итгэн зөвт байдалд хүрсэн хүн амаараа тунхаглавал авралд хүрнэ гэсэн үг билээ.

Тэгвэл, зүрх сэтгэлдээ итгэн зөвт байдалд хүрнэ гэж юу гэсэн үг вэ? Ром 2:13-д, “Учир нь Хуулийг сонсогчид нь Бурханы өмнө зөв байх бус, харин Хуулийг биелүүлэгчид нь зөвтгөгдөх болно” гэсэн байдаг билээ. Бурханы үгийг сонсоод үнэхээр итгэж байгаа бол тэр үгийн дагуу заавал үйлддэг учир энэ үйлсийн учир зөвтгөгддөг билээ.

Хайрт итгэгч та бүхэн, Хүний Хүүгийн мах ба цусыг хичээнгүйлэн идэж уун, үйлстэй итгэлээр Бурханыг баярлуулан бүх зүйлд амжилт олохыг Эзэний нэрээр хүсэн ерөөе!

Mongolian

## Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

---

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,  
152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
<http://www.manmin.org/english>  
e-mail: [manminministry@hotmail.com](mailto:manminministry@hotmail.com)  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин


### Монгол Манмин Төв Сүм

#### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

#### Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С  
**Утас:** чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

[www.manmin.org](http://www.manmin.org)  
[www.manmintv.org](http://www.manmintv.org)



# “Залбирлыг яагаад чангаар дуудах хэрэгтэй вэ?”

## Асуулт:

Би удаан хугацаанд Бурханы өмнө чимээгүй бясалган залбирах нь ариухан бөгөөд хүндэтгэлтэй хийжбуй хэрэг гэж боддог. Гэтэл Библи дээр Бурхан айлдахдаа чангаар дуудан залбирах ёстой гэсэн ишлэл. Яагаад чангаар дуудан залбирах ёстой юм бэ?

## Хариулт:

Иеремиа 33:3-д “Намайг дууд, Би чамд хариулж, чиний мэдэхгүй аугаа хүчит зүйлийг Би чамд ярина” хэмээн амлан айлдсан байдаг. Бурхан биднийг дуудан залбир гэж айлдаж, хариулж өгөхөө амласны учир нь бид дуудан залбирах үед элдэв бодолд автах юм уу, нойрмоглол зүүрмэглэх явдал байхгүй бөгөөд чин сэтгэлээсээ залбирдаг юм. Мэдээж, цуглаан эхлэхээс өмнө эрт ирээд залбирах юм уу, шөнө гэртээ ирээд залбирах үед хажуу хөрш айлдаа саад болохгүйн тулд чимээгүйхэн залбирах хэрэгтэй. Ийм тохиолдол биш л бол залбиралдаа бүх анхаарлаа хандуулан чангаар дуудан залбирах нь Бурханы хүсэл билээ.

Бурханы таалан хүлээн авч хариулдаг залбирал бол дуудан залбирах юм.

Лук 22:44-д, үзвэл бид Есүс дуудан залбирч байсныг мэдэж болох юм. Ямар их хичээн чин сэтгэлээсээ залбирсан болоод хөлс нь гарч газарт дусахдаа цусан дусал болох вэ?

Библид Есүсээс гадна олон итгэлийн дээд өвөг дээдсүүд Бурханд залбирахдаа дуудан залбирсан тухай тэмдэглэл олон байдаг. Мосе, Самуел болон Стефан зэрэг итгэлийн өвөг дээдсүүд дуудан залбирах үед Бурхан тэдний залбиралд хариулж өгсөн билээ. (Египетээс гарсан нь 15:22-25, Тооллого 12-р, бүлэг 1 Самуел 7:7-10, Үйлс 7:54-60)

Зарифатын бэлэвсэн эмэгтэйн хүү нас барахад Елиа эш үзүүлэгч Ёхова Бурханы өмнө дуудан залбирснаар хүү амилж, (Хаадын Дээд 17:17-24) аварга загасны гэдсэнд орсон Иона Бурханд хандан чангаар дуудан залбирахад аврагдан гарах боломжтой байдаг (Иона 2-р Бүлэг) сохор Бартимай хэмээх нэгэн ядуу гуйлгачин хүн чанга дуудсанаар хардаг болж ерөөлийг хүртсэн билээ. (Марк 10:46-52)

Дуудан залбирна гэдэг нь Бурханд

тэр хэмжээний чин сэтгэлээсээ өндөр дуугаар гуйн залбирна гэсэн үг юм. Ийм залбиралаар дамжуулан Ариун Сүнсээр бялхан дүүрч дайсан сатан болон муу ёрын сүнснүүдийн уруу татлагыг хөөн зайлуулдаг ба бүр цаашлан гайхамшигт үйлсийг мэдрэх боломжтой юм. Тийм үед л бид Есүс Христийн жинхэнэ гэрчлэгч болох бөгөөд Ариун Сүнсний үйлддэг эрх мэдэлт хүчит үйлс илрэн гардаг.

Дуудан залбирах нь Бурханы хуулийн дагуу хариулт авах болзол хангадаг.

Анхны хүн Адам нь сайн мууг мэдүүлэгч модны жимсийг идсэнээс болж хараал хүртэн хүн төрөлхтөн хөлсөө дуслуулан байж хөдөлмөрлөн түүнийхээ үр шимийг нь идэх болсон билээ (Эхлэл 3:17-19) Мэдээж Эзэн дахин амилснаар бүх л хараал устсан боловч хүн ялзарч муудах махан биенийг өмссөн болохоор хөлсөө дуслуулан хөдөлмөрлөж байж л амьдрах боломжтой болсон юм. 2 Тессалоник 3:10-д, “Хэрэв хэн нэгэн ажил хийхгүй бол бүү идэг” хэмээн айлдсан байдаг. Тиймээс залбирал хийхдээ хөлс гаргал дуудан залбирах хэрэгтэй билээ.

Мөн нэг зүйлийг сайтар санах хэрэгтэй. Бурхан бидний зүрх сэтгэлийн гүнийг сайн мэдэх хэдий ч тэнгэр элч нар мэдэхгүй тул амаараа дуу гарган залбирах ёстой билээ. Яагаад гэвэл тэнгэр элч нар тэр залбиралын сонсон, залбирлын анхилуун үнэрийг тэргүүн тэнгэр элчид, тэргүүн тэнгэр элч нь Бурханы сэнтийн өмнө өргөдөг билээ. Тиймд бид бүхэн дуудан залбирал хийх үед Бурханы сэнтийн өмнө өргөгдөж хариултаа авдаг.

“Дотоод өрөөндөө орон залбир” гэсний сүнсэлгэ утга учир

Зарим хүмүүс хэлэхдээ, Матай 6:6-д, “Харин чи залбирахдаа дотоод өрөөндөө орж хаалгаа хаагаад, нууцаар

оршигч Эцэгтээ залбир” хэмээн айлдсан боловч яагаад заавал дуудан залбирах ёстой юм бэ гэж асууцгаадаг. Библид буй Бурханы үг нь Ариун Сүнсний удирдамж ба бялхал дотор бичигдсэн бөгөөд энэ үгийн сүнс зүгийн утгыг сайтар ойлгох хэрэгтэй билээ.

Есүс ууланд бүх л шөнөжингөө залбирч, (Лук 6:12)-д, хүн байдаг газраас холдон үүрээр залбирч байлаа (Марк 1:35). Дотоод өрөөнд орж залбирал огт хийгээгүй билээ. Даниел цонхоо онгойлон Иерусалим руу чиглэн залбирдаг байсан ба (Даниел 6:10), Петр байшингийн дээвэр дээр залбирдаг байсан болон (Үйлс 10:9) ба элч Паул залбирлын газар очоод залбирсан байдаг (Үйлс 16:13-16). Тэд бүгд чин сэтгэлээсээ чангаар дуудан бүх зүрх сэтгэлээрээ залбирцгаадаг байсан байлаа.

Тэгвэл, Есүс “дотоод өрөөндөө орж залбир” гэсэн үг нь ямар утгатай юм бол? Библи дээр, “өрөө” гэдэг нь “хүний зүрх сэтгэл” гэсэн утгатай юм. Дотоод өрөөндөө ороод хаалгаа хаах мэт залбирал хийхдээ бүх л бодол санаа ба дэлхий зовиол, санаа зоволтыг хойш нь тавьж зүрх сэтгэлээ нэгтгэн байж залбир гэсэн утгатай билээ.

Энэ нь тухайн үеийн ахлах тахилч нар болон, фарисайчууд зам хавьд хүмүүсээр магтагдаж, өөрийгөө илэрхийлэх гэж чанга дуугаар залбирдаг тухай анхааруулсан үг юм. Есүс тийм залбирлыг Бурхан хүлээж авдаггүй болохыг мэдүүлэх гэж энэ үгийг заан айлдсан юм. Өөрөөр хэлбэл, чин сэтгэлээсээ залбирах хэрэгтэй болохыг сурган айлдсан байдаг.

Тиймээс, бид залбирал их хийдэг гэдгээрээ бахархах сэтгэлээр залбирал хийлгүй зөвхөн бидний зүрх сэтгэлийг хардаг, бүх л нөхцөл байдлыг минь мэддэг Бурхан гуйх зүйлийг минь бүгдийг өгдөг бүгдийг Эзэн болсон Бурхандаа л зүрх сэтгэлээ зориулан залбирах хэрэгтэй билээ.

## Библийн нэр томъёо

### ◆ Хэлээр ярих гэдэг нь юу гэсэн үг вэ?

Бурханы бүхий л хүүхдүүддээ Ариун Сүнсний бэлэг (1 Коринт 12:10)-үүдийн дундаас хэлээр ярин залбирахыг хүсдэг билээ (1 Коринт 14:5). Хэл ярин залбирах нь Бурханд өөрийн сүнсний гүн зүйлүүдийг илчлэн ярьдаг залбирал учраас дайсан сатан, муу ёрын саад болох боломжгүй бөгөөд сүнсэлгэ итгэлийн өсөлтөнд зайлшгүй хэрэгтэй зүйл юм.

Бидний сэтгэлд орших Ариун Сүнс бидний гуйх ёстой зүйлсийг минь залбирдаг бөгөөд би өөрөө ч мэдэхгүй, Бурханы мэлхийн өмнө хамгийн хэрэгтэй зүйлийг зохистой байдлаар гуйснаараа хариултаа маш хурдан авдаг. Мөн түүнчлэн, Ариун Сүнсээр бялхах үед махан биений ядарсан байдлыг ялан дийлэх бөгөөд сорилт шалгалтыг ч холдуулах боломжтой юм.

Мөн Ариун Сүнс Бурханы гүн зүйлийг ч хүртэл нэвтгэлдэг учраас сүнсэлгэ хүн болох тусам Бурхантай илүү ойр харилцаа тогтоож, ирээдүйн байдлыг мэдэх боломжтой болдог. Энэ мэт хэлээр ярих залбирал хийвэл тэнгэрийн орны тэмүүлэлээр дүүрэн өгөгдөх ба итгэлээр бялхам дүүрэх тул сүнс сэтгэл нь сайжрах ерөөл хүртэж бүх зүйл амжилттай болдог.

Гэвч хэлээр ярин залбирал хийсэн ч гэсэн зүрх сэтгэлийн хүсэл, залбирлын сэдэвтэй хариулт авах боломжгүй бөгөөд (1 Коринтын 14:14)-д дурдсан шиг зүрх сэтгэлээрээ ч мөн залбиран хариултаа авах ёстой билээ. Тиймд хэлээр ярин залбирах нь бидний сүнсний залбирал бөгөөд сүнс сэтгэл сайжрахын төлөө залбирдаг бол, эсрэгээр нь зүрх сэтгэлээрээ залбирна гэдэг нь эхлээд Бурханы хаанчлал Түүний зөвт байдлын төлөө залбирах ба дараа нь энэ дэлхийд амьдармагцаа тохиолдох асуудлуудыг шийдэх залбирал өөрөөр хэлбэл гэр бүл, ажил төрөл, хүсэл мөрөөдөл гэх мэт зүйлсийн төлөө залбирч хариултаа авах юм. Тиймээс, зүрх сэтгэлээрээ болон сүнсээрээ хослуулан залбирдаг хүчирхэг итгэлийн амьдралаар амьдрахыг хүсэн ерөөе!

## Улаанбаатар Манмин Сүм

### Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

### залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

### Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712

976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com



# Хойд Америкийн салбар сүмүүдийн нэгдсэн зуны цуглаан аз жаргалтай болж өнгөрлөө.

Өнгөрөгч 2012 оны Долдугаар сарын 9-ноос 12-ны хооронд 3шөнө, 4өдрийн турш И Хи Сон пасторын (Манмин Төв Сүмийн дэд пастор) удирдан явуулсан “Хойд Америкийн нэгдсэн зуны цуглаан” Канад улсын Калгори хотын Виктори библийн коллеж дээр өнгөрөв. Тус зуны цуглааны үйл ажиллагаанд “Сүнс” (Иохан 4:24) хэмээх сэдэвтэй зуны цуглааны сургалт семинар болон цаашид хойд америкт сайн мэдээ тараах алсын харааны тухай ярилцлага, спортын тэмцээн, галын наадмын үйл ажиллагаа зэрэг ивээл дүүрэн хөтөлбөрүүдээр дүүрэн байлаа. Тус үйл ажиллагаанд Америкийн Хойд Каролина, Чикаго, Нью Жерси, Вашингтон, Нью-Йорк, Сакраменто болон Лос Анжелос ба Канадын Торонто, Эдмонтон, Ванкувер, Калгори зэрэг хотуудаас ирсэн пастор номлогч нар итгэгчид оролцсон ба тэд нар нэгэн дор цуглан байгааг харахад сэтгэл хөдлөм мөчүүд байлаа. Ялангуяа 7-р сарын 17нд Америк Калифорни Манмин сайн мэдээ тараах төвийн нээлтийн цуглаан болж өнгөрсөн юм.



## Ариун Сүнсээр нэгдсэн СЭТГЭЛ ХӨДЛӨМ МӨЧ

**Ким Чунхо пастор**  
(Канад, Калгори Манмин Сүм)

Энэ удаагын зуны цуглаан нь Хойд Америк дахь бүсийн салбар сүмүүд Ариун Сүнсээр нэгдэн оролцсон пастор, номлогч нар болон итгэгч нарт төдийгүй Хойд Америк даяар интернэтээр дамжуулан ариун сайн мэдээгээр ивээл хүртэж, итгэгч нар сүнс зүгийн хүч ба урам зоригийг авсан ерөөлт цаг мөчүүд байлаа. Ялангуяа, Манминий хоёр дахь үе, англи хэлтэй номлогч нар Хойд Америкийн бүс нутагт сүмийн үйл ажиллагаанд хамтран оролцох боломж олдсон нь үнэхээр завшаантай хэрэг юм.

И Хи сон пасторын сэтгэл хөдлөм үг сургаал ба залбиралд ивээлээр дүүрч, үүлээр нарыг халхалж, сэвэлзүүр сайхан салхитай таатай цаг агаар, бүгд хайр дотор нэгдсэн спортын тэмцээн, итгэл ба хайрын үйлсээр Бурханыг баярлуулах Хойд Америкийн салбар сүмүүд болохыг хүсэн, магтаал ба залбирал, сэтгэл хөдлөм галын наадам зэрэг үнэхээр аз жаргалтай цаг мөчүүд байсан юм. Тэнгэр ажиглах үйл ажиллагаанд Сүнсний орон зайг мэдрэх боломж олдож, тэнгэрийн орны тэмүүлэлээр дүүрэн болсон юм.

Нью-Йорк, Калифорни, Калгори салбар сүмүүдийн Эмэгтэйчүүдийн баг, Хүүхдийн баг, сурагчдын багийнхны чин сэтгэлээсээ бэлдсэн урлагын тоглолт болж оролцогч нарт баяр хөөрийг өгч байлаа. Ялангуяа Сөүлээс ирсэн (Манмин Төв Сүмийн) “Эрх мэдэлт хүч” баг бяцхан хүүхдүүд мэт баяртайгаар магтан дуулж, үйлчилж байгаа байдлыг хараад ивээл хүртэж, онцгой дуу болгонд халуухан алга ташилтаар дахин тоглож өгөхийг хүсэн Бурхандаа алдрыг өргөж байлаа.

Бялхам дүүрэн ивээлээр хамтдаа байсан Бурхандаа бүхий л талархал ба алдрыг өргөн, хайраар залбирал хийж өгсөн тэргүүн пасторгаа баярлалаа.

## Гэмшил ба шийдвэр гаргах цаг, шинэ эхлэл

**Шим Жеймс пастор**  
(АНУ-ын Нью-Йорк Манмин олон улсын сүм)

Энэхүү зуны цуглаанаар дамжуулан манай итгэгчид чин зүрх сэтгэлээр бат итгэлтэй болж манай Нью Йорк, Хойд Америкт ариун сайн мэдээ ба эрх мэдэлт хүчний үйлсийг зоригтойгоор тунхаглахыг зорьсон билээ. 2006 онд Доктор И Жей руг пасторын удирдсан “Нью-Йоркын нэгдсэн их цуглаан”-аар дамжуулан цацагдсан ариун сайн мэдээний үрээр арвин их үр жимс ургуулахыг төлөө залбирсан энэ удаагын үйл ажиллагаанд бэлдсэн билээ.

Доктор И Жей руг пасторын удирдсан “2011 оны Удирдагчдын сургалт Семинар” ба “2012 оны ахлагч удирдагчдын сургалт” дээр үндэслэсэн сургалтаар дамжуулан айлдсан И Хи сон пасторын сургаалиар дамжуулан маш хурдан итгэлийн хадан суурийг суурилан, түүний дараа сүнслэг, төгс сүнслэг зүрх сэтгэлтэй болцгооё гэсэн урам зориг дүүрэн авсан юм.

Мөн Бурханаас нээж өгсөн сүнсний орон зайгаар дамжуулан Калгорын цагаан шөнийн тэнгэрт бүжиглэн хөдөлж буй одод, төрөл бүрийн хэлбэр дүрс бүхий өнгөт гэрлүүдийг харсан итгэгч нарт итгэл болж Бурханы хайраар дүүрсэн цаг байлаа.

Ялангуяа сүмүүдийн номлогч нар цуглан үүрийн залбирал хийхэд гэмшил ба шинээр эхлэх эхлэл ба ерөөлийн цаг хором байлаа. Гал мэт залбирлаар Бурхандаа найдаж чадаагүй, өөрсдийн ажил үүргийнхээ төлөө чин сэтгэлээсээ гэмшицгээсэн юм. Үүний хамт ариун санй мэдээ ба тэргүүн пасторын эрх мэдэлт хүч чадлаар эр зоригтойгоор Нью-Йорк болон Хойд Америкт болон дэлхий хандан давших ажилтан болохыг хүсэн зүрх сэтгэлээ шинэчилсэн юм.

Бидний төлөө залбирал хийж өгсөн Доктор И Жей руг пасторгаа талархлаа илэрхийлэн, хайр ба хичээл зүтгэлээ харамгүй хайрласан И Хи сон пастор болон зуны цуглааны төлөө үйлчилж арвин хайраар үлгэрлэж өгсөн Калгори Манмин Сүмийн итгэгч нарт баярласнаа илэрхийлье.

## Калифорни Манмин сайн мэдээ тараах төвийн нээлтийн үйл ажиллагаа

**Ким Хан ёол СМТ**  
(АНУ-ын Калифорни Манмин сайн мэдээ тараах төв)

Х о й д А м е р и к и й н с а л б а р с ү м ү ү д и й н н э г д с э н з у н ы ц у г л а а н а а р дамжуулан авсан Бурханы ивээл ба



сэтгэл хөдлөл дотор 2012 оны Долдугаар сарын 17-ний өдөр И Хи сон пасторыг урин Калифорни мужын Манмин сайн мэдээ тараах төвийн нээлийн үйл ажиллагаа болж өнгөрөв.

Америкийн Баруун хязгаарт номлогчоор илгээгдсэний дараа би хаана үйл ажиллагаагаа эхлэх талаар залбирч байтал Бурханаас энэ газарт солонго татуулан үзүүлж өгсөн бөгөөд энэ газрыг сонгосон билээ. Бурхан хүсэл таалалд итгэн зөвхөн залбирал дотор бүх зүйлийг Бурхандаа даатгаж байлаа.

Анхандаа гэртээ залбирах нь тохиромжгүй байсан тул машин дотроо, мөн граж дотор, бойлерийн өрөөний хажуу жижиг зайд залбирдаг байлаа. Ариухан хүчит сайн мэдээг тунхагладаг ажилчин болсондоо юу юунаас ч илүүтэй талархаж байлаа.

Цаг хугацаа өнгөрөх тусам, би залбирал хийх газар ба цуглаан хийх газар зайлшгүй хэрэгтэй болов. Тиймээс Доктор И Жей руг пасторт залбирлын хүсэлтээ илгээж, залбирал хүртэхэд хариултаа авсан юм. Байршил сайтай газар байсан тул түрээсийн төлбөр ч маш үнэтэй боловч би хагас үнээр түрээслэх боломжтой байв.

Ингээд ариун сайн мэдээг тунхаглаж эхлэхэд олон хүмүүс үүнийг хүлээж байсан гэдгийг ухаарч мэдсэн юм. Тэдгээр хүмүүс, “энэ сургаал нь миний амьдралыг болон миний сэтгэл зүрхийг хөдөлгөн өөрчилж байна” хэмээн гэрчилцгээж байлаа. Одооноос эхлэн би номлолын үйл ажиллагаагаа улам батжуулан сэргэлтийг авахын төлөө бүх хүчээ зориулах болно. Нээлтийн үйл ажиллагаа явуулах боломж олгосон Бурхан Эцэгтээ алдар ба талархалыг өргөн барья.



Баруун талын зураг баруун эгнээнээс, Шим Жеймс пастор, Ким Хан ёол СМТ, Ким Чунхо пастор, И Жей бэг СМТ, ба Жон Тэ мон пастор